



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/363

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 76 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202203054 дугаар бүхий Шарга сумын Дунд шарын аманд шинээр баригдах услалтын систем, боомтын барилгын ажлын зураг төслийг боловсруулах ажлыг "Хидро инженеринг" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумьяабазар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ